



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/25

Номгон

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 02 сарын 12-ны өдрийн 228 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай .

Ажлын хэсгийн дарга: Т.Хишигбаатар –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: О.Эрдэнэ-Оюун- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд С.Байгалмаа – Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Э.Ганзориг – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ж.Баттөр – Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Д.Алтангэрэл – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Б.Жамьяндорж –Санхүү, төрийн сангийн хэлтсийн Орлогын мэргэжилтэн

Т.Норовринчин - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Н.Одончимэг – Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

П.Отгонбаяр - Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

Л.Мандаахүү – Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл


1-р багийн иргэн

1010057

2.

2. “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах” ажлын хэсгийн тайланг 06 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг /Т.Хишигбаатар/-т үүрэг болгосугай.

3. “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах” ажлын хэсэгт хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН